



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 3/26

Улаанбаатар хот

Н.Дагвадоржийг шилжүүлэн
ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Нацагдоржийн Дагвадоржийн гаргасан хүсэлтийн дагуу 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс тус хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн хуулийн этгээдийн улсын бүртгэгчээр шилжүүлэн ажиллуулсугай.

2.Н.Дагвадоржийн төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээг ТЗ-7-д хамааруулж, зэрэг дэвийн нэмэгдлийг 20 хувиар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон хоол унааны нөхөх төлбөрийг холбогдох журмын дагуу тооцон олгохыг Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Төрхүү)-т зөвшөөрсүгэй.

3.Н.Дагвадоржийн иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлан, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нэвтрэх эрх нээж, ажлыг бүрэн хүлээлгэн өгөхийг Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Төрхүү)-т даалгасугай.

4.Н.Дагвадоржид 37/1-02 дугаартай улсын бүртгэгчийн тэмдэг хэрэглэхийг зөвшөөрсүгэй.


5.Төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг танилцуулахыг нэгжийн нууц хамгаалах ажилтан (Б.Төрхүү)-д үүрэг болгосугай.

6.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Л.Нямдаваа)-т даалгасугай.

ДАРГА

Д.ДАВААНЯМ

21/5



Handwritten signatures and stamps at the bottom of the document, including a date stamp 20260508.